

МОНГОЛ-ХЯТАДЫН ХАРИЛЦАА ДӨЧИН ЖИЛД

Ж. Бямбасүрэн

Билгийн тооллын XVII жарны шаргачин могой жил 1989 онд БНХАУ-ыг тунхагласан ба БНМАУ, Шинэ Хятад улстай дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ой тохиож буй учир Монгол, Хятадын харилцааны түүхэнд чухал онцлогтой жил юм.

БНМАУ, БНХАУ-ын найрамдал, хамтын ажиллагаа нь өнө удаан жилийн түүхэн уламжлалд үндэслэсэн хөрш улсуудын харилцаагаар төдийгүй Азийн социалист хоёр орны ард түмний зорилго нэгтэй тэмцлийн үр дүнгээр тодорхойлогдоно.

Дэлхий дахинаа социализм хүрээгээ тэлж, эрч хүчээ авч байсан үе— 1949 оны аравдугаар сард Хятадад ардын ардчилсан хувьсгал ялж, БНХАУ байгуулагдсанаар дорнодахины ард түмний үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэлд бас нэг түүхэн чухал ялалтыг авчирсан юм. «Өнөөгөөс эхлэн БНХАУ байгуулагдаж Ардын төв засгийн газар байгуулсан нь манай хоёр орны ард түмний сайн хөршийн харилцаанд шинэ үеийг нээж байна»¹ гэж БНМАУ-ын Засгийн газар тэр үед мэдэгдэж байлаа.

Гэвч энэ шинэ үед тус хоёр орны харилцаа ямагт хэвийн тогтвортой, сайнаар хөгжиж ирсэнгүй, цаг үеийн байдлаас хамаарч, өрнөлт бууралт, саад бэрхшээлтэй тулгарсаар ирэв. Тиймээс уг харилцааны 1949 оноос эдүгээ хүртэлх үеийг онцлог шинжээр нь гурван үед тоймлон хувааж болно гэж бид үзэж байна. Үүнд нэгд, 1949—1950-иад оны сүүлч буюу БНМАУ, БНХАУ-ын бүх талын харилцаа хэвийн хөгжиж, хоёр орны хооронд ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагаа гүнзгийрэн энэ нь Монгол, Хятадын ард түмний эрх ашигт, улмаар Ази болон дэлхий дахины бодит социализм, энх тайвны үйл хэрэгт нийцэж байсан үе; хоёрт, 1960-аас 1970-аад оны сүүлч буюу БНХАУ-ын тухайн үеийн удирдлагаас олон улсын харилцаанд болон улс орныхоо дотоодод явуулсан алдаатай бодлогын улмаас хоёр орны харилцаа олон талаар муудаж, зогсонги байдалд орсон үе; гуравт, 1980-аад оны эхнээс Монгол, Хятадын харилцааг сайжруулах талаар нэлээд ахиц гарч, аажимдаа хэвийн болж эхэлсэн үе зэрэг юм.

* * *

Гоминьданы харгис дэглэм, гадаадын империалистуудын өнгөлзлөг, түрэмгийллийн эсрэг Хятадын Коммунист Нам, ард түмний явуулсан олон жилийн шударга тэмцлийг эхнээс нь тууштай дэмжиж байсан монголын ард түмэн Хятадын хувьсгалын ялалтын тухай мэдээг баяртай угтаж, БНХАУ-ыг байгуулагдсан даруйд нь хүлээн зөвшөөрсөн билээ. 1949 оны 10 дугаар сарын 6-нд БНМАУ-ын Ерөнхий сайд, Гадаад явдлын яамны сайд, маршал Х. Чойбалсан БНХАУ-ын Ардын төв засгийн газрын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд, Гадаад явдлын яамны сайд Жоу Энълайд илгээлт явуулж, түүндээ БНМАУ Кантоны засгийн газраас харилцаагаа албан ёсоор тасалж, БНХАУ-ыг хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтооход бэлэн байгаагаа илэрхийлсэн байна. Уг илгээлтийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дараа ирүүлсэн хариу нотдоо нөхөр Жоу Энълай тэмдэглэхдээ,

«БНМАУ-тай даруй дипломат харилцаа тогтоож, дипломат төлөөлөгчдийн газар солилцох болсонд баяр хүргэе»² гэсэн байв. Тэгээд 1950 оны долдугаар сарын 3-нд БНМАУ-аас БНХАУ-д суух онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Б.Жаргалсайхан БНХАУ-ын Ардын төв засгийн газрын даргад, долдугаар сарын 10-нд БНХАУ-аас БНМАУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Заят (Зи Ятай) БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн даргад итгэмжлэх жуух бичгээ тус тус өргөн барьсан.

Тийнхүү БНХАУ байгуулагдаж, манай хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосноор Монгол, Хятадын харилцааны олон зууны түүхэнд цоо шинэ хуудас нээж, БНМАУ, БНХАУ-ын хооронд социалист интернационализмын зарчим, тэгш эрхийн үндсэн дээр бүх талын найрамдал, хамтын ажиллагааг хөгжүүлэх бололцоо бүрдсэн юм.

БНХАУ социалист байгуулалтынхаа эхний 10 жилд коммунист намынхаа удирдлага, ард түмнийхээ нөр хичээнгүй хөдөлмөрийн үрээр, ЗХУ болон социалист бусад орны тусламж дэмжлэгт түшиглэн маргаангүй их амжилт олж, олон улсын байр суурь нь өссөн.

Тэр үед Монгол, Хятадын ард түмний хооронд эрт цагаас тогтсон харилцан хүндэтгэл, найрамдлын үзэл санаа жинхэнэ биелэлээ олж, хоёр орны хамтын ажиллагаа нь бие биедээ бололцоотой бүх тусламж, дэмжлэгийг үзүүлэх, эдийн засаг, соёлын дэвшилд хүрэх, дэлхийн социалист системийг бэхжүүлэх, энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах талаар хамтран чармайлт тавих эрмэлзэлд бүхэлдээ чиглэж байв.

Төр, засгийн газрын дээд хэмжээний төлөөлөгчдийн удаа дараагийн харилцан айлчлалууд, 1952 онд Бээжинд гарын үсэг зурсан БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр болон бусад баримт бичгүүд хоёр орны найрамдал, хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жоу Эньлай 1952 оны хэлэлцээрт гарын үсэг зурах ёслол дээр хэлэхдээ, уг хэлэлцээр нь «Хятад, Монголын бат найрамдал, мөнхийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд түлхэц үзүүлэх төдийгүй энх тайвны төлөө манай хоёр ард түмний тэмцлийг идэвхжүүлж, империализмын эсрэг тэмцэж байгаа ЗХУ тэр хүүтэй энх тайван, ардчиллын лагерийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах нь эргэлзээгүй»³ гэжээ.

Урлаг, уран сайхны хамтлаг, үзэсгэлэн, оюутан, багш, төрөл бүрийн салбарын мэргэжилтнүүд, туршлага солилцох, ном бүтээл орчуулан хэвлэх зэргээр тэр үед зохиогдож байсан олон арга хэмжээ нь хоёр орны ард түмнийг социалист байгуулалтынхаа ололт амжилттай харилцан танилцах, ойлголцол, ах дүүгийн барилдлагааг бэхжүүлэхэд их ач холбогдолтой болсон.

Харилцан туслах, дэмжих явдал тэр үеийн монгол, хятадын харилцааны онцгой шинж байлаа. 1956 онд БНХАУ-ын Засгийн газар Монгол улсад 160 сая рублийн (хуучин ханшаар) буцалтгүй тусламж үзүүлсэн бөгөөд 1956—1959 онд БНМАУ-д Хятад улсын тусламжаар аж үйлдвэр, хөдөө аж ахуй, тээвэр, соёлын салбарын хэд хэдэн чухал объект байгуулсан юм.

БНХАУ нь манай орны социалист байгуулалтын үйлсэд зөвхөн санхүү, эдийн засаг, техникийн тусламж үзүүлсэн төдийгүй төрөл бүрийн мэргэжлийн инженер техникийн ажилтан, тусгай мэргэжлийн 10 мянга гаруй ажилчныг манай засгийн газрын хүсэлтээр түр хуга-

цаагаар ирүүлж, манай орны үйлдвэр, хөдөө аж ахуйн барилгууд дээр ажиллуулж⁴ байлаа. БНМАУ-ын засгийн газар, ард түмэн БНХАУ-ын засгийн газарт тийнхүү тусламж үзүүлсэн явдалд тухай бүрд нь гүн талархал илэрхийлж, манай социалист байгуулалтад хятад иргэдийн байгуулсан гавьяаг өндрөөр үнэлж байв.

Монгол, Хятадын харилцаанд худалдаа нь олон жилийн түүхэн уламжлалтай бөгөөд дурьдан буй үед хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны хамгийн чухал үзүүлэлтийн нэг байлаа.

1953 оны дөрөвдүгээр сард БНМАУ, БНХАУ-ын хооронд харилцан бараа нийлүүлэх, төлбөрийн тухай анхны хэлэлцээрт гарын үсэг зурсан. Хоёр орны хоорондох худалдааны эргэлт 6 жилийн дотор (1951-1956) бараг 8 дахин нэмэгдсэн бөгөөд 1959 онд 1952 оныхоос 34,6 дахин нэмэгдсэн. 1959 он гэхэд БНМАУ-ын гадаад худалдааны нийт эргэлтэд БНХАУ нь ЗСБНХУ-ын дараа хоёрдугаар байр буюу хувийн жингээрээ 15,5%-ийг эзэлж байв.

1956 оноос Москва, Улаанбаатар, Бээжинг холбосон төмөр замыг БНМАУ-ын нутгийг дайруулан байгуулж, ашиглалтад оруулсан нь зорчигчид, барааг шуурхай тээвэрлэх, өрнө, дорнын бусад улсад нэвтрэх таатай боломж нээсний зэрэгцээ тус хөрш гурван орны аж ахуй, соёлын байгуулалт, найрамдалт харилцаанд бодитой нөлөөг үзүүлж, манай улсад транзит тээврээс зохих орлого оруулж эхэлсэн юм.

БНМАУ, БНХАУ-ын харилцаанд Өвөр Монголын өөртөө засах орон чухал байр эзэлдэг. Манай улс ӨМӨЗО-той хилийн худалдаа хийж, тусламж үзүүлэх зорилгоор багш, малын эмч, зоотехникч, соёл урлагийн ажилтан нарыг илгээж байв. Мөн Өвөр Монголын малчдад байгалийн бэрхшээлтэй үед БНМАУ-ын хөрш зэргэлдээ нутагт нүүдэллэн ирж, түр суурьших зөвшөөрөл олгож байсан. Харилцаа өргөжсөнтэй холбогдуулан 1957-1959 онд БНМАУ-ын ерөнхий консулын газрыг ӨМӨЗО-ы төв Хөх хотод нээн ажиллуулж байв. Ерөөс Өвөр Монгол бол Монгол, Хятадын харилцааны онцлог нэг тал, хүчин зүйл мөн.

Улс ардын аж ахуй, соёлоо сэргээн хөгжүүлэхийн төлөө хятадын ард түмний тэмцлийг манай нам, ард түмэн бүхий л талаар дэмжин, нийт социалист системтэй нягт холбоотойгоор БНХАУ-д социализм байгуулах чиг шугамыг тодорхойлсон. ХКН-ын VIII их хурлын түүхэн шийдвэрт үнэн сэтгэлээс баяр хүргэж байлаа.

Тийнхүү БНМАУ, БНХАУ-ын харилцааны эхний 10 жилийг хоёр орны найрамдалт харилцаа, энх тайван социализмын эрх ашигт нийцсэн үе гэж авч үзэх бүрэн үндэстэй бөгөөд тэрхүү харилцаа нь пролетарийн интернационализмд тулгуурласан олон улсын харилцааны шинэ, социалист хэлбэрийн нэг жишээ юм.

Түүнчлэн 1960 онд Улаанбаатар хотноо Монгол, Хятадын харилцааны үндсэн зарчим, тухайлбал: пролетарийн интернационализм, төрийн тусгаар тогтнол ба газар нутгийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, тэгш эрх, харилцан ашигтай байх зарчмыг нарийн заан тодорхойлсон, «БНМАУ, БНХАУ-ын найрамдал, харилцан туслах тухай Гэрээ»-нд гарын үсэг зурсан. Энэ гэрээний үзэл санаа, зарчим, өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй, хүчин төгөлдөр хэвээр байна. Мөн БНМАУ, БНХАУ-ын хоорондын харилцаанд, 1962 оны арван хоёрдугаар сард хилийн гэрээ байгуулж, түүнийхээ дагуу хилээ тогтоосон нь том үйл явдал болов.⁵

Гэвч 1950-иад оны сүүлч, 60-аад оны эхээр монгол, хятадын харилцаанд сөрөг хандлага, зохисгүй үзэгдлүүд илрэн гарах болж, цаашдаа хятад орон «соёлын хувьсгал»-ын хар шуурганд бүхэлдээ нэр-

вэгдэн, хоёр улсын харилцаа 20 гаруй жилийн турш хэвийн бус, зогсонги байдалд байлаа. Энэ нь тухайн үеийн хятадын удирдлагаас олон улсын тавцан дээр болон манай улсын талаар баримталж байсан бодлого, үйл ажиллагааны шууд үр дагавар юм.

Ийм нөхцөлд ч МАХН, БНМАУ-ын Засгийн газар, хоёр орны ард түмний болон энх тайван, социализмын амин чухал эрх ашгийг удирдлага болгон БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаатай байх чиг шугамыг тууштай баримталж ирэв. МАХН-ын XIX их хурлаас «БНМАУ Бүгд Найрамдах Хятад Ард Улстай харилцаагаа хэвийн болгох зарчимч чиг шугамаа тууштай баримталсаар байна. Эрх тэгш байх, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох зарчмыг хатуу баримтлах үндсэн дээр хоёр орны хооронд сайн хөршийн харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх нь Монгол, Хятадын ард түмний эрх ашигт болон энх тайван, социализмын үйлсийн эрх ашигт нийцнэ гэж үзэж байна»⁶ гэж заажээ. Сүүлийн жилүүдэд манай нам, засгаас энэхүү чиг заалтыг тууштай баримтлан БНХАУ-тай харилцаагаа бүрэн хэвийн болгоход үйл ажиллагаагаа урьдын адил чиглүүлэн ирэв.

* * *

ХКН-ын Төв Хорооны III бүгд хурлаас (1978 оны) дэвшүүлсэн чиг шугам, шийдвэрийн дагуу БНХАУ наяд оны эхэн үеэс эдийн засгийн шинэтгэлийг эрчимтэй хэрэгжүүлж, гадаадад нээлттэй бодлого явуулан дэлхийн улс орнууд түүний дотор олонхи социалист оронтой харилцаагаа хэвийн болгон хөгжүүлэв.

Сүүлийн жилүүдэд хоёр талын хүч чармайлтын үр дүнд БНМАУ, БНХАУ-ын төр, олон нийтийн байгууллагуудын харилцаа, худалдаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагаа өргөжиж байна.

Хоёр улсын Гадаад явдлын яамны шугамаар уулзалт яриа тогтмолжин, орлогч сайд нар харилцан айлчилж, хоёр талын харилцааны болон олон улсын зарим асуудлаар санал солилцож ирэв. БНМАУ, БНХАУ-ын засгийн газар хооронд Консулын конвенц байгуулан баталж, Хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай гэрээнд гарын үсэг зурав. Хоёр орны найрамдлын байгууллагын төлөөлөгчид харилцан айлчилж байна.

МАХН, ХКН-ын харилцааг сэргээж, хэвийн болгох тохиролцоонд хүрч, үйлдвэрчин, залуучууд ба олон нийтийн бусад байгууллагууд харилцаагаа сэргээж эхлэв.

Худалдаа, эдийн засгийн харилцаа жилээс жилд өргөжих хандлагатай байна. 1986 оны 4 дүгээр сард гарын үсэг зурсан БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 1986-1990 оны худалдааны удаан жилийн хэлэлцээр ёсоор 1990 онд хоёр талын худалдааны нийт эргэлтийн хэмжээ 51,4 сая швейцар Франкад хүрч, манай улс зүсмэл банз, адууны шир, тарваганы арьс, бугын цусан эвэр зэргийг экспортлож, даалимба, торго, алим жимс, халуун сав, үзэг, будаг гэх зэрэг бүтээгдэхүүн импортоор авна.

1984 онд хоёр улсын худалдааны хэмжээ 9,7 сая швейцар франк байсан бол 1989 онд 24 саяд хүрч, 2,4 дахин нэмэгдэв. Түүний дотор манай улсын экспорт 42,8 хувиар, импорт 3,8 дахин нэмэгдсэн (хилийн худалдааг тооцохгүйгээр). 1984-1988 онд манай улс хятадын гадаад худалдааны 10 пүүсээс 15 сая, шв. франкийн өртөгтэй бараа импортоор авахаар гарын үсэг зурсны 80 хувь нь өргөн хэрэгцээний бараа, 20 хувь нь машины тоног төхөөрөмж юм.⁷

Сүүлийн үед хилийн худалдаа болон шууд бараа солилцоо түргэн хурдацтай хөгжиж байна. Зөвхөн 1988—1989 он гэхэд БНХАУ ын ӨМӨЗО, Синьзян-Уйгарын ӨЗО-той хилийн худалдаа хийх гэ-

рээнд гарын үсэг зурж, 47 сая шв. франкийн бараа солилцохоор тохирчээ.

Дээрх салбарын харилцаанд ӨМӨЗО чухал үүрэг гүйцэтгэж байна. БНМАУ-ын худалдаа, эдийн засгийн төлөөлөгчид 1989 оны хавар ӨМӨЗО-нд очиж, тус ӨЗО-ны холбогдох байгууллагын хүмүүстэй хэлэлцээ хийж, худалдаа, эдийн засгийн эрх бүхий байгууллагуудын хооронд бараа материал солилцох, эдийн засаг, техникийн хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэхээр тохиролцжээ.

БНХАУ-ын Засгийн газраас БНМАУ-ын Засгийн газарт 1958, 1960 онуудад олгосон зээл, түүний хүүг төлөх талаар хэлэлцээ хийж холбогдох протоколд 1986 оны 1 дүгээр сарын 15-нд гарын үсэг зурснаар олон жил шийдэгдээгүй байсан асуудлыг шийдвэрлэв.

Төмөр замын ачаа тээврийн талаар хэлэлцээр байгуулж, хамтын ажиллагаагаа хөгжүүлж байна. Түүний зэрэгцээ БНМАУ-ын Иргэний агаарын тээврийг удирдах ерөнхий газар Улаанбаатар-Бээжингийн агаарын нислэгийг 1986 онд сэргээн цаашид тогтмол нислэг хийж эхэлсэн нь тус хоёр орны хоорондох зорчигч тээврийн харилцаа, олон улсын жуулчлалыг хөгжүүлэхэд таатай нөхцөл бүрдүүлж байна.

БНМАУ, БНХАУ-ын Засгийн газар хооронд 1958 онд байгуулсан соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийн зарчмын дагуу сүүлийн жилүүдэд тус хоёр орны соёлын харилцаа сэргэн хөгжиж байна. 1986 оноос хоёр орны хооронд нэг, хоёр жилийн хугацаатай соёлын солилцооны төлөвлөгөөнд гарын үсэг зурж, түүний дагуу урлагийн хамтлагууд айлчлан тоглох, уран зураг, гар урлалын үзэсгэлэн гаргах, зохиолч, эрдэмтэн, тамирчид харилцан айлчлах зэрэг төрөл бүрийн ажил, арга хэмжээнүүд зохиогдож байна. Уг төлөвлөгөө ёсоор адил тооны мэргэжилтэн багш, оюутан, мэргэжил дээшлүүлэгч харилцан илгээж, уран сайхны болон баримтат кино, ном хэвлэл, дуу хөгжмийн бичлэг солилцож ирлээ.

Мөн БНМАУ, БНХАУ-ын хооронд 1987—1990 онд шинжлэх ухаан, техникийн талаар хамтран ажиллах төлөвлөгөөний төслийг тохиролцсон бөгөөд жил, жилийн төлөвлөгөө ёсоор хөдөө аж ахуй, хөнгөн, хүнс түлш эрчим хүчний салбарын чиглэлээр хамтран ажиллах, гол нь туршлага солилцох ажээ.

Сүүлийн жилүүдэд Хятадын Хэвлэл мэдээллийн байгууллагууд хоёр орны харилцааны холбогдолтой мэдээнээс гадна манай улсын дотоод, гадаад бодлого, үйл амьдралын тухай нэлээд нийтлэх болж, манай ном зохиолыг орчуулан хэвлэх (ялангуяа ӨМӨЗО-нд монгол бичигт хөрвүүлэх) сонирхол эрс дээшлэв.

Монгол, Хятадын харилцаа бүх талаар ийнхүү сэргээн идэвхжиж байгаа үед, 1989 оны хавар БНМАУ-ын Гадаад явдлын яамны сайд Ц. Гомбосүрэн БНХАУ-ын Гадаад явдлын яамны сайд Цянь Цичэний урилгаар тус улсад албан ёсоор айлчилж нөхөр Цянь Цичэнтэй хэлэлцээ хийн, БНХАУ-ын БНХАУ-ын зарим удирдах хүмүүстэй, уулзаж, харилцааны гурван чухал баримт-бичиг Эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны комисс байгуулах тухай, иргэд харилцан зорчих журмын тухай, БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрүүдэд гарын үсэг зурав. Тус хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосноос хойшхи 40 жилд БНМАУ-ын Гадаад явдлын яамны сайдын Хятад улсад хийсэн анхны энэхүү айлчлал нь хоёр орны сайн хөршийн харилцаа, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхэд төдийгүй уг ажиллагааг бүрэн хэвийн болгож, чанарын хувьд шинэ үе эхлүүлэхэд дорвитой хувь нэмэр орууллаа хэмээн үзэж болох юм.

Түүнчлэн энэ оны намар БНХАУ-ын Гадаад явдлын яамны сайд Цянь Цичэнь БНМАУ-д хариу айлчилж, үр дүнтэй яриа хэлэлцээ

хийлээ. БНМАУ, БНХАУ-ын бүх талын харилцаа сүүлийн жилүүдэд хэлбэрэлтгүй сайжирч байгаа нь монгол, Хятадын ард түмний язгуур эрх ашигт, зүй ёсоор нийцэж байна.

Эцэст нь тэмдэглэхэд, дэлхий дахины байдалд эргэлтийн шинжтэй өөрчлөлт гарч, олон улсын харилцаанд улс төрийн шинэ сэтгэлгээ тууштай нэвтэрч буй өнөөгийн нөхцөлд бүрэн хэвийн болох зүгт эргэлт буцалтгүй чиглэсэн Монгол, Хятадын харилцаа нь урьд өмнөхөөсөө ялгаатай, шинэ маягийн харилцаа байх болно. Учир нь, найрсаг сайн харилцаатай байсан тэртээ 1950-иад он, эдүгээ үе хоёрын олон улсын харилцааны орчин нөхцөл, чиг хандлага, түүнчлэн тус хоёр орны нийгмийн хөгжил, эдийн засгийн чадавхи, дэлхийн тавцанд эзэлж буй байр суурь зэргийг орон зай, цаг хугацааны хувьд харьцуулан авч үзвэл нэн өөр болжээ.

Харин харилцааны өнө удаан жилийн уламжлал, олон талын туршлагатай хөрш зэргэлдээ манай социалист хоёр орны тухайд санал зөрөөтэй зарчмын асуудал байхгүй учраас найрамдал, харилцан туслах тухай 1960 оны гэрээний үзэл санааны дагуу энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр бүх талын харилцааг хөгжүүлэх өргөн боломж өнөө байна,

80-ААД ОНЫ ХЯТАД-АМЕРИКИЙН ХАРИЛЦАА (ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ТАЛААР)

О. Оюунгэрэл

Наяад оноос эхлэн БНХАУ-АНУ-ын харилцаа дэлхий дахины болон Ази, Номхон далайн бүс нутаг дахь улсуудын улс төрийн бодлого, хамтын ажиллагаа, түүний харилцаанд их нөлөө үзүүлж байна. Эдгээр хоёр улсын явуулж буй бодлого нь дэлхий дахинд нөлөө бүхий байр суурь эзэлдэгээс гадна нийгмийн өөр өөр байгуулалтай энэ улсуудын харилцааны онцлог шинж чанар нь ихэнхдээ тухайн үеийн олон улсын байдал, уур амьсгалаас хамаарч ирсэн билээ.

Гадаадын зарим хятад судлаачдын тэмдэглэснээр, маогийн бодлогын уршгаар Хятад орныг сүйрэлд хүргэсэн байдлаас аврах арга замыг Дэн Сяопин ба түүний талынхан сонгож авчээ. Хятадын удирдлага улс орныхоо эдийн засгийн гол гол салбарыг өрнөдийн хөрөнгө оруулалт, техник-технологийн мэргэжилтний тусламжтайгаар хөгжүүлэхийг голчлон зорьж байна. Наяад оны Хятадын технологийн

Өгүүллийн зүүлт

1. «Үнэн» 1949 10. 7.
2. «Үнэн», 1949, 10, -19,
3. «Жэньминь жибао» 1952. 10, 5.
4. «Үнэн». 1959, 9. 18
5. М. С. Капица, БНХАУ: гучин жилд гурван бодлого, .. - УБ: 1984, "207-р тал..."
6. Ж. Батмөнх, МАХН-ын XIX их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан, цаашдын зорилт. УБ., 1986, 14-р тал,
7. «Монголын мэдээ» сонин (хятад хэлээр) 1989, 7. 1.